



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 4/341

Мандалговь

Г Сургалт зохион байгуулах тухай Г

Нэгжийн тухай хуулийн 66.1, Дайчилгааны тухай хуулийн 18.1.4, 18.1.5, 29 дүгээр зүйл, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11.19 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2018 оны A/265 дугаар тушаал, Батлан хамгаалахын сайдын 2020 оны A/133 дугаар журам, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний ажил үйлчилгээ-4. 4.1-ийн заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 25 -ний өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Цэргийн штабын “Сургалтын төлөвлөгөө”-ний дагуу Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн Сайнцагаан сумын дэг журам сахиулахад дэмжлэг үзүүлэх сумангийн иргэдийг зарлан дуудаж, сургалтыг Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн сургалтын материаллаг баазыг түшиглэн 2022 оны 5 дугаар сарын 23-с 5 дугаар сарын 27-ны өдрийг дуустал 5 хоногийн хугацаатайгаар зохион байгуулсугай.

2. Сургалтад хамрагдах бүрэлдэхүүний хоолны зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 133 дугаар тогтоолын дагуу хүнсний хангамжийн хоногийн хэмжээг 33 хүнээр тооцож, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хүнсийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтыг хөтөлбөрийн дагуу чанартай хамтран зохион байгуулж явуулахыг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх), Цагдаагийн газрын дарга (дэд хурандаа Б.Мөнхбат), орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер (дэд хурандаа Ц.Баттулга) нарт даалгасугай.

4. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн иргэдийн сургалтын зардалд шаардагдах 4.110.862 (дөрвөн сая нэг зуун арав найман зуун жаран хоёр) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Энхмарт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4822100495